



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 460

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө залруулан бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 9 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 164,429,760.00 (нэг зуун жаран дөрвөн сая дөрвөн зуун хорин есэн мянга долоон зуун жар) төгрөгийн балансын үнэтэй, 7447 м.кв талбай бүхий газар эзэмших эрх-биет бус хөрөнгийг хэмжилтийн зөрүүний 6 м.кв талбайгаар хорогдуулж, 7441 м.кв буюу үнэлгээг 164,297,280.00 (нэг зуун жаран дөрвөн сая хоёр зуун ерэн долоон мянга хоёр зуун наян) төгрөгөөр бууруулж, залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Сүхболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

• 13?002?54
22-r huraldaan.docx